



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 411, 198 дугаар тогтоолоор
батлагдсан журмуудад нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 2 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт дор дурдсан агуулгатай 3 дахь заалтыг, 5 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт дор дурдсан агуулгатай 2, 3 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

“2.1.3. “Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа” гэж даатгагчаас олгосон бүрэн эрхийн хүрээнд даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс даатгалын гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, даатгалын нөхөн төлбөртэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг”;

“5.1.2. Даатгалын төлөөлөгч нь энэ журамд заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлснийхээ төлөө даатгагчаас төлбөр, хөлс авах эрхтэй бөгөөд уг үйл ажиллагааг явуулаагүй тохиолдолд даатгагчаас аливаа төлбөр, хөлс авахыг хориглоно”;

“5.1.3. Даатгуулагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө даатгагчаас хүлээн авч буй төлбөр, хөлсний талаар даатгалын төлөөлөгч нь даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө даатгуулагчид бичгээр мэдэгдэж, танилцуулсан байна. Энэхүү төлбөр, хөлсийг даатгалын төлөөлөгчид олгохыг зөвшөөрсөн даатгуулагчийн гарын үсэг бүхий мэдэгдлийг даатгагчид хүргүүлэх”. гэж;

2. Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт дор дурдсан агуулгатай 26 дахь заалт, 5 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт дор дурдсан агуулгатай 7 дахь заалт, 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 11 дэх хэсгийг нэмсүгэй:

“3.1.26. Даатгагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, хувьцаат компани, гадаадын хөрөнгө оруулалттай компанитай гэрээ байгуулсных нь төлөө даатгалын төлөөлөгчид олгосон төлбөр, хөлс, даатгуулагч, даатгалын

000000

гэрээний талаарх мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу улирал бүр гарган Хороонд хүргүүлж, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод зарлан мэдээлэх”;


“5.1.7. Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 5.1.3-д заасан шаардлагыг биелүүлээгүй даатгалын төлөөлөгчид аливаа төлбөр, хөлс төлөх, өөрийн нэрийн өмнөөс даатгалын гэрээг байгуулах эрх олгохыг хориглоно”;

“5.11. Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 2.1.3-т заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлээгүй даатгалын төлөөлөгчид аливаа хөлс, төлбөр төлөхийг хориглоно” гэж.

3. Энэ тогтоолыг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.


ДАРГА



З.НАРАНТУЯА

Хорооны 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн
277 тоот тогтоолын хавсралт

“Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж
мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 2 дугаар хавсралт



ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ОЛГОСОН ШИМТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

20.... оны улирал

д/д	Даатгалын төлөөлөгчийн нэр	Даатгуулагчийн нэр ¹	Байгууллагын төрөл ²	Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн дүн ³
1				
2				
3				

¹ Даатгуулагчийн нэрийг товчлолгүйгээр бүрэн бичнэ.

² Байгууллагын төрлөөр дараах дугаарыг бичнэ: Төрийн байгууллага -1, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж -2, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж -3, Хувьцаат компани – 4, Гадаадын хөрөнгө оруулалттай компани – 5. Хэрвээ байгууллагын төрөл давхцсан тохиолдолд дугааруудыг хамтад нь бичнэ.

³ Тухайн улиралд даатгуулагчтай байгуулсан нийт гэрээний орлогоос олсон шимтгэлийн дүнг бичнэ.